



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Арга хэмжээ авах тухай

Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 83 зүйлийн 83.1, МХБ ТӨХК-ийн Дүрэм"-ийн 8.1, 8.10.11, МХБ ТӨХК-ийн "Хяналтын журам"-ын 37.2 дахь заалт, "Гишүүнчлэлийн журам"-ын 9.2, 9.4 дахь заалт, "МХБ-ийн гишүүдийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 2.1, 2.5, 5.2 дахь заалт, МХБ ТӨХК-иас гишүүн компанитай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний 2.4.3, 2.4.11, 2.4.14 дахь заалт, "Үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 4.8, 7.3, 7.4 дахь заалт, Хяналтын албаны 2014 оны №1 актыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МХБ ТӨХК-ийн "Гишүүнчлэлийн журам", "Хамтран ажиллах гэрээ" болон бусад холбогдох гэрээний заалтуудыг зөрчсөн "Эм Ай Си Си" ХХК-ийг 500,000 төгрөгөөр торгосугай.
2. "Эм Ай Си Си" ХХК-ийн ажилтан Э.Оюу нь МХБ-ийн үнэт цаасны арилжааны Трейдэр програмд хандах эрхийг бусдад шилжүүлж, ажлын хариуцлага алдсан тул сануулах арга хэмжээ авсугай.
3. Цаашид үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг "Эм Ай Си Си" ХХК-ийн захирал /Д.Ачит-Эрдэнэ/, ажилтан /Э.Оюу/ нарт хатуу анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР